

Иргэн таны хууль эрх зүйн мэдлэгт

➤ Засгийн газрын 2018 оны 182-р Тогтоол гарсантай холбогдуулан Улсын статистикийн газарт мал бүхий өрхөөр бүртгэгдсэн өрхүүдээс тавиул мал байрлаж буй газар нутгийн бүсчиллээс хамааран хонин толгой тутамд Бэлчээрийн газрын төлбөр ноогдуулж, төлбөрийг 2019.01.01-ны өдрөөс эхлэн ноогдуулж эхэлсэн тул мал бүхий өрхүүд жилд төлөх төлбөрөө хугацаанд нь барагдуулж байхыг хүсье. Төлбөр барагдуулаагүй өрхөд ГМСангаас төлбөр+алданги тооцохыг анхааруулж байна.

➤ Мөн дээрх тогтоол гарсантай холбогдон газрын төлбөрийн хэмжээнд өөрчлөлт орсон тухайлбал: Өвөлжөө, хаваржааны газрын жилийн төлбөр 2800 байсан бол 2018 оны 01 сараас эхлэн 4200 төгрөг болж өөрчлөгдсөн.

- Өвөлжөө 4200 төгрөг

- Хаваржаа 4200 төгрөг тус тус зориулалтаар авсан гэрчилгээний тоогоор газрын төлбөр төлнө.

➤ **Газрын нэгдсэн цахим мэдээллийн сан нэвтэрсэнтэй холбогдуулан** хүчин төгөлдөр бүхий захирамж шийдвэртэй газрыг бүрэн зурагжуулж /координаттай/ цахимжуулан УБГазраас "Э" дугаар олгодог болсонтой холбогдон газар эзэмших эрхийн гэрчилгээний үнэт цаас шинэчлэгдсэн тул 2018 оноос өмнө олгосон газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэх ажил хийгдэж байна.

Жич: Гэрчилгээ шинэчлэхэд шаардлагатай материал:

- Газрын гэрчилгээ эх %, гэрээний хамт

- Иргэний үнэмлэх

- Тухайн багийн ЗДаргаас болон Газрын даамлаас Газрын байршилын Координат

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИАР ГАЗРЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ

8.1 дүгээр зүйл. Газрын тухай хууль зөрчих:

8.2 дугаар зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль зөрчих

1. Газар өмчлөх эрх бүхий иргэн хуульд заасан үүрэг, эсхүл хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Өмчилж авсан газраа кадастрын, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх, өмчийн газраа бусад иргэний өмчлөлд шилжүүлэх, бусдад эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон журам, эсхүл барьцааны гэрээ, эд хөрөнгө өмчлөх эрхээ улсын бүртгэлд бүртгүүлэх журам зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Тогтоосон цэгт байрлуулсан заагийн цэг, геодезийн цэг, тэмдэгтийг хамгаалах, бүрэн бүтэн байлгах, эсхүл газрын төлөв байдал, чанарыг дордуулахгүй байх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Иргэн газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд нь аливаа хэлбэрээр саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Шинээр газар өмчлөх тухай хүсэлт гаргах Газар өмчлүүлэхэд тавигдах шаардлага:

➤ Таны согонгосон газар нь ГЗБ-ын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөнд иргэнд өмчлүүлэхээр тусгагдсан байх

➤ Бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай ямар нэг хэлбэрээр давхцаагүй байх

Газар өмчлөх тухай хүсэлт гаргах:

➤ Газар өмчлөх тухай өргөдөл, түүнд дагалдах баримт бичгийг бүрдүүлэн тухайн сум, орон нутгынхаа Газрын даамалд хандана. (өргөдлийн маягтыг Газрын даамлаас авна)

➤ Таны өргөдлийг Газрын даамал хүлээн авч хянаж үзээд шаардлага хангасан тохиолдолд бүртгэж энэ тухай тодорхойлолт хийж өгнө, шаардлага хангаагүй тохиолдолд танд материалыг буцаан олгоно

➤ Газрын даамал шаардлага хангасан материалыг тухайн шатны Засаг даргад танилцуулж Засаг дарга таныг газар өмчилж авах эрх бүхий этгээд болохыг нотолсны үндсэн дээр танд газар өмчлүүлэх тухай захирамж гаргана.

Газар өмчлөгч иргэн дараах үүрэгтэй:

➤ Хууль тогтоомжид заасны дагуу газрын улсын бүртгэлийн кадастрын зураг хийлгүүлэх

➤ Өмчийн газрынхаа заагийг газар дээр нь тэмдэгжүүлэх (хашаа барих)

➤ Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгүүлэх

➤ Газар өмчилж авах тухай өргөдөлд хавсаргах баримт материалыг үнэн зөв бүрдүүлэх

ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАХ

Газар эзэмшүүлэхэд тавигдах шаардлага:

Хүсэлт гаргасан газар нь аймаг, сумын ГЗБТЖ-ийн Төлөвлөгөөнд иргэн, ААНБ-д эзэмшүүлж болохоор заагдсан, мөн бусдын эзэмшиж ашиглаж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна.

Газар эзэмшүүлэх хугацаа:

Газрыг Монгол улсын иргэн аж ахуйн нэгж байгууллагад 15-60 жил хүртэл хугацаатайгаар эзэмшүүлж болно.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг нэг удаад сунгах хугацаа 40 жилээс илүүгүй байна.

Газар эзэмших тухай хүсэлт гаргах

Иргэн газар эзэмших тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад баталсан загварын дагуу гаргана.

Хүсэлтэд дараах зүйлийг тусгана:

- Овог, нэр, байнга оршин суугаа хаяг иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар,
 - Эзэмших газрын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн харъяалал, Газар эзэмших зориулалт хугацаа
- ### Аж ахуйн нэгж байгууллага
- Аж ахуйн нэгж байгууллагын оноосон нэр, харъяалал, хаяг улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 - Эзэмших газрын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн харъяалал, хэмжээ зааг байршил нэгж талбарыг харуулсан тойм зураг
 - Газар эзэмших зориулалт хугацаа

Иргэн та МУИГӨТХууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасны дагуу өмчийн газраа улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулан газар өмчлөх эрхийн “УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ” авах үүрэгтэй.

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ

Эрхийн гэрчилгээг шилжүүлэх хүсэлтийг талууд гаргах бөгөөд дараах бичиг баримтыг хавсаргана.

- Газар эзэмших эрхийн гэрчилгээ
- Эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч
- байгаа этгээд нь уг эрхийн гэрчилгээг

шилжүүлэн авснаар үүсэх эрх, үүргийг

➤ бүрэн хүлээн зөвшөөрч байгаа тухай нотолгоо

- Иргэний үнэмлэхийн болон ААНэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргана.

Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох, бусдад шилжүүлэх, гэрчилгээний хугацаа сунгахад төлөх хураамжийн хэмжээ

Гэрчилгээний үнэ:

Иргэнд	3000₮
ААНБ	5000₮

Хувийн хэргийн үнэ 8430 ₮

Тэмдэгтийн хураамж :

Иргэн	6000₮
ААНБ	10000₮

Кадастрийн үнэ: 2500₮

Газар эзэмших эрхийн гэрчилгээгүрэгдүүлсэн тохиолдолд түүнийг нөхөн олгоход хураамжийн хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлж тооцно.

Газар өмчлөх, эзэмшихтэй холбоотой гэрчилгээний үнэ, үйлчилгээний хураамж:

1. Газар өмчлөх эрхээ анх удаа бүртгүүлж баталгаажуулахад:

Хувийн хэргийн үнэ 8430 ₮

Кадастрийн үнэ /1%/ 2500 ₮

ИРГЭН ТА ЭХ ОРНЫХОО “ГАЗАР” ХЭМЭЭХ ХАМГИЙН БОДИТ ӨМЧИЙН ЭЗЭН БОЛОХ БОЛОМЖ НЭЭЛТТЭЙ БАЙНА.

ЛАВЛАХ Утас: 88997774, 95750047

Өвөрхангай аймаг Тарагт сум ЗДТГазар



Гарын авлага

2020 ОН

